ХӨВСГӨЛ АЙМАГ
ЦАГААН-УУЛ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 12 сарын 02 өдөр          Дугаар 49          Шарга

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
хуралдаан зарлах, хэлэлцэх асуудал
батлах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, Нутаг Дэвсгэрийн Нэгж, Түүний Удирдлагын Тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалтыг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас **ТОГТООХ НЬ:**

**1.** Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит VIII хуралдааныг 2014 оны 12 дугээр сарын 16-ны өдрийн 10 цагт Соёлын төвд хуралдуулсугай.

**2.** Тус хуралдаанаар дор дурьдсан асуудлуудыг хэлэлцүүлэхээр тогтоосугай.

1. "Галт дулаан" ОНӨААТҮГ-ын 2015 оны үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөө батлах тухай.

2. "Эшт сүндэл хайрхан" ОНӨААТҮГ-ын 2015 оны үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөө батлах тухай.

3. 2014 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт, Газрын төлбөр, татварын үнэлгээний бүсийг тогтоох, 2015 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай.

4. Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийн Нэгдсэн төлөвлөгөө батлах тухай.

5. Сумын 2014 оны төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэл, 2015 оны орон нутгийн орлогын төлөвлөгөө, Төсвийн төсөл батлах тухай.

6. Төсвийн эрх захирагч нарын 2015 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнг хэлэлцэж батлах тухай

001[illegible]

**3.** Хуралдааны бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөөг хавсралтаар батласугай.

**4.** Хуралдааны бэлтгэл ажлыг хангах, хуралдааны зар хүргэх ажлыг зохион байгуулахыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /Л.Сэрсмаа /, Тамгын газрын даргыг түр орлон гүйцэтгэгч /Т.Мөнхбаяр/ нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА Ч.АЗБАЯР

00117

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2014 оны 12 дугаар сарын 02 -ны
.49. дугаар тогтоолын Хавсралт

## ЦАГААН-УУЛ СУМЫН ИТХ-ЫН ЭЭЛЖИТ VIII ХУРАЛДААНЫ БЭЛТГЭЛ ХАНГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хийгдэх ажлууд | Хугацаа | Хариуцах эзэн | Хяналт тавих эзэн |
|---|---|---|---|---|
| 1 | Хуралдааны зар хүргэх, хуралдааны танхим бэлтгэх | 2014.12.10-2014.12.13 | ЗДТГ-ын даргын түр орлон гүйцэтгэгч Т.Мөнхбаяр, ИТХ-ын нарийн бичгийн дарга Л.Сэрсмаа | ИТХ-ын дарга |
| 2 | "Галт дулаан" ОНӨААТҮГ-ын 2015 оны үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөө батлах тухай. | 2014.12.10-2014.12.13 | Д.Мягмар, Г.Оюунчимэг | ИТХ-ын Тэргүүлэгчид |
| 3 | "Эшт сүндэл хайрхан" ОНӨААТҮГ-ын 2015 оны үйлдвэр санхүүгийн төлөвлөгөө батлах тухай. | 2014.12.10-2014.12.13 | Т.Ганчулуун Х.Бямбасүрэн | ИТХ-ын Тэргүүлэгчид |
| 4 | | 2014.12.10-2014.12.13 | Татварын байцаагч Н.Ганбаатар Төрийн сангийн төлөөлөгч Ш.Эрдэнэцэцэг | ИТХ-ын Тэргүүлэгчид |
| 5 | | 2014.12.10-2014.12.13 | ЗДТГ-ын даргын түр орлон гүйцэтгэгч Т.Мөнхбаяр, Төрийн сангийн төлөөлөгч Ш.Эрдэнэцэцэг | ИТХ-ын Тэргүүлэгчид |
| 6 | Сумын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, 2015 онд төсвөөс санхүүжих хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг батлах тухай | 2014.12.10-2014.12.13 | Засаг дарга Д.Түмэнбаяр, | ИТХ-ын Тэргүүлэгчид |
| 7 | Төсвийн эрх захирагч нарын 2015 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнг хэлэлцэж батлах тухай. | 2014.12.10-2014.12.13 | ЗДТГ-ын даргын түр орлон гүйцэтгэгч Т.Мөнхбаяр, Л.Сэрсмаа, Төсвийн менежерүүд | ИТХ-ын Тэргүүлэгчид |
| 8 | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2014 оны зарцуулалтын тайлан 2015 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг батлах тухай. | 2014.12.10-2014.12.13 | ЗДТГ-ын даргын түр орлон гүйцэтгэгч Т.Мөнхбаяр, Төрийн сангийн төлөөлөгч Ш.Эрдэнэцэцэг | ИТХ-ын Тэргүүлэгчид |
| 9 | Худалдан авах ажиллагааны 2015 оны төлөвлөгөөг батлах тухай. | 2014.12.10-2014.12.13 | Э.Эрдэнэцэцэг | ИТХ-ын Тэргүүлэгчид |